



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/85

Улаанбаатар хот

### Дэн буудлын зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан "Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөн барилгажуулах журам"-ын 10.1, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөн барилгажуулах болсонтой холбогдуулан Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, 2-р хороолол, 20 дугаар байрны нэг давхарт дэн буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн Д.Дашдуламын "Сарнай" дэн буудлын зөвшөөрлийг барилга дахин ашиглалтад орох хүртэл түр хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Энэхүү тушаалыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг мэргэжилтэн С.Туулд даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА